



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 5/38

Ховд

Г.Өөдэйг ажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.5 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 241 дүгээр “Хяналт шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд Төрийн албаны хуулийн дагуу шилжүүлэн ажиллуулж байсан Галаагийн Өөдэйг аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын албан тушаалаас 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

